



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠢᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠠᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/02

Алтай хот

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.10 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Монгол Улсын Засгийн газраас баримталж буй Төсвийн шинэчлэлийн бодлогын хүрээнд орон нутгийн төсвийн орлогын суурь баазыг нэмэгдүүлэх шинэ сэргэлтийн бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангуулах, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 09 дүгээр хуралдаанаар баталсан тогтоолуудын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга) (зөвшилцсөнөөр)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

(Цэргийн штабын дарга)

(Татварын хэлтсийн дарга)

(Цагдаагийн газрын дарга)

2.

- (Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай аймаг дахь хэлтсийн дарга) (зөвшилцсөнөөр)
- (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга)
- (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
- (Соёл, урлагийн газрын дарга)
- (Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн дарга)
- (Орон нутгийн өмчийн газрын дарга)
- (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
- (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
- (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
- (Автотээврийн төвийн дарга)
- (Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)
- (Эрүүл мэндийн газрын дарга)
- (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
- (Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)
- (Гаалийн хорооны дарга)
- (Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга)
- (Онцгой байдлын газрын дарга)
- (Сумдын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн орон нутгийн удирдлага, сум агентлаг хариуцсан мэргэжилтэн)
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын мэргэжилтэн)
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, төрийн бус байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн)
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дэд бүтцийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

2. Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар ханган сум, байгууллага, аж ахуйн нэгжид хүрч ажиллан тогтоол шийдвэрийн биелэлтийг хуулийн хүрээнд хэрэгжүүлж ажиллах, ажлын төлөвлөгөө гарган батлуулж зорилтоо биелүүлэх, ажлын явц үр дүнг улирал бүр Засаг даргын Удирдлагын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Хариуцсан салбартай холбоотой болон ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг заасан хугацаанд чанартай гүйцэтгэж, ажлын хэсгээс зохион байгуулж буй ажилд биечлэн оролцож санаачилгатай ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР